

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/11

Сүмбэр сум

Төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 17, 18 дугаар бүлэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь Биеийн тамир спортын улсын хорооны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилтын 3 дугаар арга хэмжээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагч, ажилчдын 2021 онд хэрэгжүүлэх "Ажиллах нөхцөл, Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г 1дүгээр хавсралтаар, Төрийн албан хаагч, ажилчдын 2021 онд хэрэгжүүлэх "Сургалтын төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлагнахыг Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах албаны дарга М.Батдэлгэрт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг төсөвт жил бүр тусгаж байхыг ня-бо /Б.Лүнгэрэгжанцан/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БУЯАНТОГТОХ



Биеийн тамир, спортын газрын даргын  
2021 оны 4 дугаар сарын 15 ны өдрийн  
А/ // дугаар тушаалын 3 хавсралт

**Биеийн тамир, спортын газрын албан хаагч, ажилчдын нийгмийн  
баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2021 онд зохион байгуулах ажлын  
төлөвлөгөө**

| №  | Хийгдэх ажил  | Хугацаа       | Хариуцах эзэн          |
|----|---|---------------|------------------------|
| 1. | Улс, олон улсын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож амжилт гаргасан багш, дасгалжуулагч, эрхэлсэн идвэхи санаачлагатай ажилласан ажилчдыг шагнаж урамшуулах. | Сар бүр       | М.Батдэлгэр            |
| 2. | Албан хаагч, ажилчдын дунд соёл, спорт, эрүүл мэндийн арга хэмжээг тогтомол зохион байгуулах.   | 7 хоног бүр   | Эмч Г.Цэнгэмаа         |
| 3. | Албан хаагч, ажилчид унааны зардал-1200төг, хоолны 3000 төгрөгийг олгоно.   | Сар бүр       | Ня-бо Б.Лүнгэрэгжанцан |
| 4. | Албан хаагч, ажилчдыг нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэгт бүрэн хамруулах.   | Жилдээ        | Ня-бо Б.Лүнгэрэгжанцан |
| 5. | Ажилтан, албан хаагчдад халуун аарц, чацаргана өгөх, витаминжуулах.   | 1,4-р улиралд | Нярав Н.Эрдэнэцэцэг    |
| 6. | Хүүхдийн баяраар ажилчдын 16 нас хүрээгүй хүүхдүүдийн дунд хөгжөөнч тоглоом, арга хэмжээг зохион байгуулж, бэлэг өгнө.  | 2-р улиралд   | Мэргэжилтэн Б.Уянга    |
| 7. | Албан хаагч, ажилчид техник, багаж хэрэгсэлээр хангах.  | Жилдээ        | Ня-бо Б.Лүнгэрэгжанцан |

Төлөвлөгөө гаргасан:

БТСБХЗАлбаны дарга

М.Батдэлгэр

Биеийн тамир, спортын газрын даргын  
2021 оны 4 дугаар сарын 28 ны өдрийн  
А/11 дугаар тушаалын 2 хавсралт



**Биеийн тамир спортын газрын албан хаагчийн сургалтын  
хөтөлбөрийн хүрээнд 2021 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө**

| №  | Сургалтын сэдэв   | Хугацаа       | Санхүүжүүлэх эх үүсвэр                           | Зохион байгуулах албан хаагчид                          |
|----|---|---------------|--|---|
| 1. | Дотоод эрх зүйн сургалтыг зохион байгуулах.   | Сар бүр       | Байгууллагын төсөв                               | Дотоод сургалт хариуцсан ажилтан болон, мэргэжилтэнгүүд |
| 2. | Мэргэжилтнүүдийг гадаад, дотоод сургалтанд хамруулах.   | Жилдээ        | Улс болон, орон нутгийн төсөв Байгууллагын төсөв | Мэргэжилтэн   |
| 3. | Биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулж буй цахим болон танхимын сургалтанд мэргэжилтэн, багш дасгалжуулагч нарыг хамруулах. | Жилдээ        | Улсын төсөв Байгууллагын төсөв                   | Мэргэжилтнүүд   |
| 4. | Спортын холбоодуудын цахим удирдах ажилтны сургалт зохион байгуулах.  | 1-р улиралд   | Байгууллагын төсөв                               | Биеийн тамир, спортын мэргэжилтэн                       |
| 5. | Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлал, сургалтанд хамрагдах.                                      | 2,4-р улиралд | Байгууллагын төсөв                               | БТСУХ, Биеийн тамирын хэлтэс                            |
| 6. | Санхүүгийн ажилтныг сургалтанд хамруулах.   | Удирдам жаар  | Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв            | Төрийн сангийн хэлтэс                                   |
| 7. | Нярав, бичиг хэргийн ажилтаныг сургалтанд хамруулах.  | Жилдээ        | Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв            | АЗДТГазар   |
| 8. | Монгол үндэсний олимпын хорооноос зохион байгуулж буй сургалтанд хамруулах.   | Жилдээ        | Байгууллагын төсөв                               | МҮОХороо  |
| 9. | Бусад холбогдох цаг үеийн сургалтанд мэргэжилтнүүд, багш дасгалжуулагч нарыг хамруулах.   | Жилдээ        | Улс болон, орон нутгийн төсөв Байгууллагын төсөв | Мэргэжилтэн, багш дасгалжуулагч нар                     |

Төлөвлөгөө гаргасан:  
Мэргэжилтэн Б.Уянга